БҮГД НАЙРАМДАХ ХЯТАД АРД УЛС БЭЭЖИН ХОТЫН ДӨРӨВДҮГЭЭР ДУНД ШАТНЫ АРДЫН ШҮҮХ ИРГЭНИЙ ХЭРГИЙН ТУХАЙ ТОГТООЛ

（2024）京 04 民特 409 号

Өргөдөл гаргагч: Хятадын Экспорт-Импортын банк. Хаяг: Бээжин хот, Шичэн дүүрэг, Фусинмэньнэй өргөн чөлөө, 30 тоот.

Хууль ёсны төлөөлөгч: У Фулинь, Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга.

Итгэмжлэгдсэн төлөөлөгч: Лю Жуо, Бээжингийн “Жиньлу Аньшэн” хуулийн фирмийн өмгөөлөгч.

Итгэмжлэгдсэн төлөөлөгч: Гун Юэ, Бээжингийн “Жиньлу Аньшэн” хуулийн фирмийн Шэньжэнь дэх салбарын өмгөөлөгч.

Хариуцагч: “Инфинити Спейс” хязгаарлагдмал хариуцлагатай компани (Infinity Space LLC). Хаяг: Монгол Улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 6 дугаар хороо, Бага тойруу, 27 тоот.

Эрх бүхий төлөөлөгч: Батчулууны Алтантуул (Altantuul Batchuluun), гүйцэтгэх захирал.

Итгэмжлэгдсэн төлөөлөгч: Юй Чэньшяо, Бээжин хотын “Хуамао Гуйгу” хуулийн фирмийн өмгөөлөгч.

Итгэмжлэгдсэн төлөөлөгч: Ян Юаньчин, Бээжин хотын “Хуамао Гуйгу” хуулийн фирмийн Ханьдань дахь салбарын өмгөөлөгч.

Өргөдөл гаргагч Хятадын Экспорт-Импортын банк, хариуцагч “Инфинити Спейс” хязгаарлагдмал хариуцлагатай компани (Infinity Space LLC, цаашид “Инфинити Инфинити Спейс компани” гэх)-д холбогдох арбитрын шийдвэрийг хүчингүй болгуулах тухай хэргийг тус шүүх 2024 оны 4 дүгээр сарын 2-ны өдөр үүсгэн хянан шалгасан бөгөөд хянан шалгах ажиллагаа дууссан болно.

Хятадын Экспорт-Импортын банк дараах хүсэлт, тайлбарыг гаргав:

Хүсэлт: Хятадын Олон улсын эдийн засаг, худалдааны арбитрын комисс (цаашид “Арбитрын комисс” гэх)-оос 2023 оны 10 дугаар сарын 23-ны өдөр гаргасан (2023) CIETAC 2272 арбитрын шийдвэрийг хүчингүй болгож өгнө үү. Үйл баримт, үндэслэл: 2011 онд Хятадын Экспорт-Импортын банк Монгол Улсад байгуулагдсан “Монголын Шинэ Лалэгаотэ төмрийн уурхай” хязгаарлагдмал хариуцлагатай компанитай (цаашид “Монголын төмрийн уурхайн компани” гэх) “Зээлийн гэрээ” байгуулсан. Уг компани болон түүнийг бодитоор хянадаг Ли Шаоминг Монгол Улсад байрлах Лалэгаотэ төмрийн уурхайг худалдан авахад зориулан банк 200 сая ам.долларын зээл олгосон.

Инфинити Спейс компани зэрэг Монголын төмрийн уурхайн компанийн хамаарал бүхий компаниуд уг зээлийн үүргийн гүйцэтгэлийг хангах баталгаа гаргасан. Инфинити Спейс компани өөрийн эзэмшлийн XV-016814 дугаартай Лалэгаотэ тусгай зөвшөөрөл, түүнээс үүсэх ашигт малтмал олборлох бүх эрх болон холбогдох эрх, ашиг сонирхлыг Хятадын Экспорт-Импортын банкинд барьцаалсан. Талууд "Эрхийн барьцааны гэрээ" байгуулж, Монгол Улсад хуульд заасан журмын дагуу барьцааны бүртгэл хийлгэсэн. Монголын төмрийн уурхайн компани 2014 оны эцсээс гэрээний үүргээ зөрчиж, 200 сая ам.доллароос давсан зээлийн үндсэн төлбөр, хүүг төлөх хугацааг ихээхэн хэтрүүлсэн тул Хятадын Экспорт-Импортын банк 2019 оны 3 дугаар сарын 25-ны өдөр Инфинити Спейс компанийн барьцааны үүргийн хариуцлагыг хэрэгжүүлэхээр арбитрт нэхэмжлэл гаргасан. Гэвч хэргийг хянан хэлэлцэж, шийдвэрлэх явцад дараах асуудал гарсан.

Нэгдүгээрт, арбитрын ажиллагаа зохисгүй явагдсан. Хэрэг үүсгэх, арбитрын бүрэлдэхүүн байгуулах, шийдвэр гаргах хугацаа тус бүр хэт удаан үргэлжилж, арбитрын дүрмийг ноцтой зөрчсөн бөгөөд ажиллагааны ноцтой доголдолтой байсан. Хятадын Экспорт-Импортын банк 2019 оны 3 дугаар сарын 25-ны өдөр арбитрт нэхэмжлэл гаргаж, 2019 оны 7 дугаар сарын 24-ний өдөр англи орчуулгыг бүрэн хүргүүлсэн боловч Арбитрын комисс 2019 оны 12 дугаар сарын 2-ны өдөр л Инфинити Спейс компанид баримт бичиг хүргүүлэх ажиллагааг эхлүүлсэн. Арбитрын бүрэлдэхүүнийг 2020 оны 6 дугаар сарын 23-ны өдөр байгуулж, шийдвэрийг 2023 оны 10 дугаар сарын 23-ны өдөр гаргасан нь хэт удаан хугацаа юм. Анхны хуралдааныг 2020 оны 9 дүгээр сарын 23-ны өдөр хийсний дараа хоёр дахь хуралдааныг 2023 оны 5 дугаар сарын 18-ны өдөр товлосон бөгөөд хоёр хуралдааны хоорондох хугацаа хэт урт байсан. Арбитрын ажиллагаа нь "Хятадын Олон улсын эдийн засаг, худалдааны арбитрын комиссын арбитрын дүрэм" (цаашид "Арбитрын дүрэм" гэх)-д заасан шийдвэр гаргах хугацааг ноцтой хэтрүүлсэн.

Тодруулбал, Арбитрын дүрмийн 48 дугаар зүйлийн (1)-д "Арбитрын бүрэлдэхүүн байгуулагдсанаас хойш 6 сарын дотор шийдвэр гаргана" гэж заасан. Шийдвэр гаргах хугацааг удаа дараа сунгах тухай Арбитрын комиссын мэдэгдэлд Арбитрын шүүхийн дарга зөвшөөрсөн гэж тодорхой дурдсан боловч мөн зүйлийн (2)-т хугацааг сунгахад бодитой, хүндэтгэн үзэх шалтгаан байх бөгөөд шаардлагатай зорилгын хүрээгээр хязгаарлагдах ёстойг тодорхой заасан. Талуудын өмнө хүндэтгэн үзэх шалтгааныг тайлбарлаагүй атлаа ийм урт хугацааны турш шийдвэр гаргах хугацааг удаа дараа сунгасан нь Арбитрын дүрмийн 48 дугаар зүйлийн шийдвэр гаргах хугацааны тухай журмыг илт зөрчсөн.

Хоёрдугаарт, арбитрын ажиллагааны үе шат бүрд гарсан ноцтой, үндэслэлгүй саатал зэрэг ажиллагааны доголдол нь Инфинити Спейс компанид Хятадын Экспорт-Импортын банкны барьцааны эрхээ хэрэгжүүлэхэд саад учруулах хууль бус арга хэмжээг санаатайгаар авах хангалттай хугацаа олгож, Хятадын төрийн өмчийг завших хууль бус зорилгодоо хүрэх нөхцөл бүрдүүлсэн. Хятадын Экспорт-Импортын банк

арбитрт нэхэмжлэл гаргасны дараа Инфинити Спейс компани Монгол Улсад захиргааны хэрэг үүсгүүлж, холбогдох барьцааны бүртгэлийг хүчингүй болгуулахыг оролдсон. Хятадын Экспорт-Импортын банк уг хэрэгт оролцон эрхээ хамгаалсны үр дүнд Инфинити Спейс компани зорилгодоо хүрээгүй. Үүний дараа Инфинити Спейс компани нэн даруй эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа эхлүүлж, тухайн хэрэгт хуурамч нотлох баримт гарган өгч, худал мэдүүлэг өгсөн. Улмаар Хятадын Экспорт-Импортын банкинд хууль ёсны мэдэгдэл хүргүүлээгүй байхад Монгол Улсын эрүүгийн хэргийн шүүх “Эрхийн барьцааны гэрээ”-г хүчин төгөлдөр бус гэж үзэж, барьцааны бүртгэлийг хүчингүй болгохоор шийдвэрлэсэн нь банкны зээлдүүлэгчийн болон үүргийн гүйцэтгэлийн баталгаатай холбоотой эрх, ашиг сонирхлыг ноцтой хохироож, төрийн санхүүгийн хөрөнгөд хохирол учруулсан.

Гуравдугаарт, арбитрын шийдвэр нь нийгмийн нийтийн ашиг сонирхолд харшилсан. Арбитрын шийдвэрт дурдсанаар, Хятадын Экспорт-Импортын банкны арбитрын нэхэмжлэлийг эцэст нь хэрэгсэхгүй болгосон шалтгаан нь Монгол Улсын эрүүгийн хэргийн шүүх “Эрхийн барьцааны гэрээ”-г хүчин төгөлдөр бус гэж үзэж, маргаан бүхий барьцааны бүртгэлийг хүчингүй болгохоор шийдвэрлэсэнтэй холбоотой. Арбитрын бүрэлдэхүүн Монгол Улсын эрүүгийн хэргийн шүүхийн шийдвэрийг үнэмшилтэй гэж хүлээн зөвшөөрөөгүй бөгөөд уг шийдвэрийн хууль ёсны болон үндэслэлтэй байдалд ноцтой доголдол байгааг харгалзан үзсэн атлаа уг шийдвэрийг энэ хэрэгт чухал нөлөөтэй нотлох баримт, эрх зүйн баримт бичиг гэж үзэн хүлээн авч, түүнд үндэслэн арбитрын шийдвэр гаргасан. Монгол Улс, БНХАУ-ын хооронд Монгол Улсын эрүүгийн хэргийн шүүхийн шийдвэрийг хүлээн зөвшөөрч, гүйцэтгэх тухай хоёр талт гэрээ байхгүй. Ийм шийдвэрт үндэслэн арбитрын шийдвэр гаргасан нь БНХАУ-ын шүүх эрх мэдлийн бүрэн эрхт байдалд бодитоор халдаж, БНХАУ-д хүлээн зөвшөөрөөгүй Монгол Улсын эрүүгийн хэргийн шүүхийн шийдвэрийг БНХАУ-ын хэргийн оролцогч талд эрх зүйн үр дагавартай болгосон бөгөөд хуульд заасан журмыг зөрчсөн. Түүнчлэн уг арбитрын шийдвэр нь Монгол Улс шүүх эрх мэдлийн бүрэн эрхээ урвуулан ашиглаж, өр төлөгчийг залилан мэхлэх, тэр ч байтугай хууль зөрчих, гэмт хэрэг үйлдэх аргаар өр төлбөрөөс зайлсхийхийг өөгшүүлсэн үйлдлийг хүлээн зөвшөөрсөн. Энэ нь Хятадын Экспорт-Импортын банкны хууль ёсны эрх, ашиг сонирхлыг зөрчиж, төрийн санхүүгийн хөрөнгөд ноцтой хохирол учруулаад зогсохгүй, БНХАУ-ын хөрөнгө оруулагчдын гадаадад санхүүгийн үйл ажиллагаа явуулах дэг журмыг ноцтой алдагдуулж, санхүүгийн тогтвортой байдал, аюулгүй байдалд халдан, тодорхой этгээдээр хязгаарлагдахгүй нийт хөрөнгө оруулагчдын олон улсын санхүүгийн үйл ажиллагаанд оролцох аюулгүй байдал, итгэлийг эрсдэлд оруулсан. Иймд нийгмийн нийтийн чухал ашиг сонирхолд хохирол учруулж, хуулийн эрх тэгш, шударга ёсны үндсэн зарчим, нийтийн дэг журам, нийтээр хүлээн зөвшөөрсөн ёс суртахуунд харшилж байна.

Инфинити Спейс компани Хятадын Экспорт-Импортын банкны хүсэлтийг зөвшөөрөхгүй гэж мэдэгдэж, дараах үндэслэлийг гаргав:

Нэгдүгээрт, арбитрын ажиллагаа нь арбитрын дүрмийг зөрчөөгүй. Ажиллагаа сунжирсан нь Хятадын Экспорт-Импортын банкнаас шалтгаалсан. Арбитрын анхны хуралдаан 2020 оны 9 дүгээр сарын 23-ны өдөр болсон боловч банк 2022 оны 4 дүгээр сарын 18-ны өдөр нэхэмжлэлийн шаардлагаа өөрчлөх хүсэлт гаргаж, арбитрын хураамжийн нэмэлт төлбөрийг 2023 оны 3 дугаар сард л төлсөн тул хоёр дахь хуралдааныг хийхэд хүрсэн. Банк маргаан бүхий барьцааны бүртгэлийн байдлыг 2023 оны 9 дүгээр сард л тайлбарласан. Энэ нь ажиллагаа сунжирсан бүх шалтгаан Хятадын Экспорт-Импортын банкнаас үүдэлтэйг харуулж байна.

Хоёрдугаарт, Инфинити Спэйс компани өр төлбөрөөс зайлсхийгээгүй. Монгол Улсад гаргасан захиргааны нэхэмжлэл нь хууль ёсны эрх, ашиг сонирхлоо хуульд нийцсэн аргаар хамгаалсан үйлдэл юм. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг Хятадын Экспорт-Импортын банкны санаачилга, оролцоогоор эхлүүлсэн бөгөөд банк уг ажиллагааны талаар мэдэж байсан. Арбитрын бүрэлдэхүүн Монгол Улсын эрүүгийн хэргийн шүүхийн шийдвэрийг өөрийн шийдвэрийн үйл баримтын үндэслэл болгоогүй тул арбитрын хэрэг нь уг эрүүгийн шийдвэрийг хүлээн зөвшөөрөх, гүйцэтгэх асуудалтай холбоогүй.

Гуравдугаарт, Инфинити Спейс компани арбитрын шийдвэрийн дагуу төлсөн арбитрын хураамжийг Хятадын Экспорт-Импортын банк хүлээн авсан тул банк уг шийдвэрийг дагаж мөрдөх ёстой.

Дөрөвдүгээрт, Хятадын Экспорт-Импортын банк зээлд хяналт тавих үүргээ зөрчин зээлийг зохисгүй олгож, хяналтаа сулруулсны улмаас маргаан бүхий зээлийг гэрээнд заасан зориулалтаар ашиглаагүй. Үүнээс үүдсэн бүх хохирлыг банк өөрөө хариуцах ёстой.

Тавдугаарт, Хятадын Экспорт-Импортын банк, Инфинити Спейс компани нь эрх зүйн байдлын хувьд тэгш худалдаа, аж ахуйн субъектүүд юм. Маргаан бүхий арбитрын шийдвэр нь зөвхөн тэдгээрийн хоорондын гэрээний эрх, үүргийн харилцааг шийдвэрлэсэн бөгөөд нийгмийн бусад гишүүний хууль ёсны эрх, ашиг сонирхлыг шууд болон шууд бусаар хөндсөн нөхцөл байхгүй. Иймд уг шийдвэр нийтийн ашиг сонирхолтой холбоогүй бөгөөд түүнд харшлаагүй.

Тус шүүх хянан шалгаад дараах үйл баримтыг тогтоов. Арбитрын нэхэмжлэгч Хятадын Экспорт-Импортын банк Инфинити Спейс компанитай байгуулсан “Тусгай зөвшөөрлийн эрхийн барьцааны гэрээ”-ний арбитрын заалт болон холбогдох хууль тогтоомжид үндэслэн, Инфинити Спейс компанийг хариуцагчаар татаж, Арбитрын комисст бичгээр нэхэмжлэл гаргасан. Арбитрын комисс хэргийг хүлээн авч, X20191265 дугаар олгон, 2015 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс мөрдөгдөж эхэлсэн Арбитрын дүрмийг хэрэглэж хянан хэлэлцсэн. Хятадын Экспорт-Импортын банк дараах шаардлага гаргасан: XV-016814 дугаартай Larlegaote тусгай зөвшөөрөл, түүнээс үүсэх ашигт малтмал олборлох бүх эрх болон холбогдох эрх, ашиг сонирхлыг дуудлага худалдаагаар худалдах, шууд худалдах зэрэг хуулиар олгосон аливаа болон бүх эрхийг

хэрэгжүүлэх замаар захиран зарцуулж, үүнээс олсон орлогыг банкны зээлийн үндсэн төлбөр, хүү болон бусад төлбөрийг төлөхөд ашиглах эрхтэй болохыг тогтоолгох.

2023 оны 10 дугаар сарын 23-ны өдөр Арбитрын комисс (2023) CIETAC 2272 шийдвэр гаргасан. Арбитрын бүрэлдэхүүн Монгол Улсын эрүүгийн хэргийн шүүхийн шийдвэрийн үндэслэлд санал нийлэхгүй байгаа боловч маргаан бүхий барьцааны бүртгэлийг эцсийн дүнд бодитоор хүчингүй болгосон учир Хятадын Экспорт-Импортын банк уг барьцааны хувьд нэгдүгээр ээлжид шаардлагаа хангуулах барьцааны эрхээ цаашид хэрэгжүүлэх эрхгүй гэж үзсэн. Арбитрын шийдвэрийн үр дүн: (1) Хятадын Экспорт-Импортын банкны арбитрын нэхэмжлэлийн бүх шаардлагыг хэрэгсэхгүй болгох; (2) энэ хэргийн арбитрын хураамж 270,000 юань бөгөөд Хятадын Экспорт-Импортын банк, Инфинити Спейс компани тус бүр хагасыг буюу 135 000 юанийг хариуцах. Банк 270,000 юанийг урьдчилан төлж, уг төлбөрийг хэргийн арбитрын хураамжид тооцсон тул Инфинити Спейс компани шийдвэр гарсан өдрөөс хойш хорин (20) хоногийн дотор банкинд 135,000 юань төлөх.

Тус шүүхийн дүгнэлт: Арбитрын хариуцагч Инфинити Спейс компани нь Монгол Улсад бүртгэлтэй хуулийн этгээд тул энэ хэрэг нь гадаадын оролцоотой арбитрын шийдвэрийг хүчингүй болгуулахаар тал хүсэлт гаргасан хэрэг болно. “Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Арбитрын тухай хууль” (цаашид “Арбитрын тухай хууль” гэх)-ийн 70 дугаар зүйлд заасны дагуу “Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль” (цаашид “Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль” гэх)-ийн 291 дүгээр зүйлд заасан асуудлыг хянан шалгана. Тус хуулийн 291 дүгээр зүйлд: “Бүгд Найрамдах Хятад Ард Улсын гадаадын оролцоотой маргаан шийдвэрлэх арбитрын байгууллагаас гаргасан шийдвэрт дор дурдсан нөхцөлийн аль нэг байгааг хариуцагч нотлох баримтаар нотолсон бөгөөд ардын шүүх шүүх бүрэлдэхүүн байгуулан хянан шалгаж, баталгаажуулсан бол уг шийдвэрийг гүйцэтгэхээс татгалзах тухай тогтоол гаргана: (1) талууд гэрээндээ арбитрын заалт тусгаагүй, эсхүл маргаан гарсны дараа бичгээр арбитрын хэлэлцээр байгуулаагүй; (2) хариуцагч арбитрч томилох, эсхүл арбитрын ажиллагаа явуулах тухай мэдэгдэл аваагүй, эсхүл өөрөөс нь үл шалтгаалах бусад шалтгаанаар тайлбар гаргах боломжгүй байсан; (3) арбитрын бүрэлдэхүүний бүтэц, эсхүл арбитрын ажиллагаа нь арбитрын дүрэмд нийцээгүй; (4) шийдвэрлэсэн асуудал нь арбитрын хэлэлцээрийн хүрээнд хамаарахгүй, эсхүл арбитрын байгууллага тухайн маргааныг шийдвэрлэх эрх хэмжээгүй байсан. Ардын шүүх уг шийдвэрийг гүйцэтгэх нь нийгмийн нийтийн ашиг сонирхолд харшилна гэж үзвэл гүйцэтгэхээс татгалзах тухай тогтоол гаргана” гэж заасан. Дээрх заалт нь ардын шүүх гадаадын оролцоотой арбитрын шийдвэрийг хүчингүй болгох хуульд заасан үндэслэл мөн. Талын гаргасан хүсэлтийн үндэслэл эдгээрт нийцэхгүй бол гадаадын оролцоотой арбитрын шийдвэрийг хүчингүй болгох үндэслэл болгож болохгүй.

Арбитрын шийдвэрийг хүчингүй болгох ёстой гэж Хятадын Экспорт-Импортын банкны гаргасан үндэслэлд тус шүүх дараах дүгнэлт хийв:

Нэгдүгээрт, арбитрын ажиллагаа зохисгүй, хэт удаан үргэлжилж, арбитрын дүрэм зөрчсөн гэх тайлбарын тухайд: Арбитрын дүрмийн 48 дугаар зүйлд шийдвэр гаргах хугацааны талаар (1) арбитрын бүрэлдэхүүн байгуулагдсанаас хойш 6 сарын дотор шийдвэр гаргана; (2) арбитрын бүрэлдэхүүний хүсэлтээр, Арбитрын комиссын Арбитрын шүүхийн дарга бодитой, хүндэтгэн үзэх шалтгаан болон шаардлага байна гэж үзвэл уг хугацааг сунгаж болно; (3) ажиллагаа түдгэлзсэн хугацааг дээрх (1)-д заасан шийдвэр гаргах хугацаанд оруулж тооцохгүй гэж заасан. Энэ хэрэгт хэргийг хянан хэлэлцэх, ажиллагааг үргэлжлүүлэх бодит хэрэгцээнд үндэслэн арбитрын бүрэлдэхүүний хүсэлтээр Арбитрын шүүхийн дарга шийдвэр гаргах хугацааг эцсийн байдлаар 2023 оны 10 дугаар сарын 23-ны өдөр хүртэл сунгахыг зөвшөөрч, шийдвэрлэсэн. Маргаан бүхий арбитрын шийдвэрийг 2023 оны 10 дугаар сарын 23-ны өдөр гаргасан тул хянан хэлэлцэх хугацааг хэтрүүлээгүй, арбитрын дүрэмд нийцээгүй нөхцөл байхгүй. Арбитрын тухай хууль болон арбитрын дүрмийн аль алинд нь хугацааг хэдэн удаа сунгаж болохыг тогтоогоогүй. Харин сунгах шалтгаан хүндэтгэн үзэх, үндэслэлтэй эсэхийг арбитрын дүрмийн дагуу Арбитрын комиссын Арбитрын шүүхийн дарга шийдвэрлэх бөгөөд энэ нь арбитрын талаарх шүүхийн хянан шалгах ажиллагааны хүрээнд хамаарахгүй. Иймд банкны энэ үндэслэлийг тус шүүх хүлээн авахгүй.

Хоёрдугаарт, арбитрын ажиллагааг зохисгүй сунгаснаар Инфинити Спейс компани хугацаа хожиж, өр төлбөрөөс зайлсхийн, банкны хууль ёсны эрх, ашиг сонирхлыг хохироосон гэх тайлбарын тухайд: энэ нь мөн чанартаа арбитрын ажиллагаанд гаргасан эсэргүүцэл юм. Тус шүүх арбитрын ажиллагаа арбитрын дүрмийг зөрчөөгүй гэж нэгэнт дүгнэсэн тул банкны энэ үндэслэлийг хүлээн авахгүй.

Гуравдугаарт, арбитрын шийдвэр нийгмийн нийтийн ашиг сонирхолд харшилсан гэх тайлбарын тухайд: нийгмийн нийтийн ашиг сонирхолд харшлах гэдэг нь нийт нийгэм ашиг хүртэгч нь болох, нийгмийг бүхэлд нь хамарсан эрх зүй, ёс суртахууны хамгийн суурь нийтлэг ашиг сонирхолд шийдвэр харшлахыг хэлнэ. Энэ нь БНХАУ-ын эрх зүйн үндсэн тогтолцоо, зарчимд харшлах, нийгэм, эдийн засгийн амьдралын суурь үнэт зүйлсийн чиг баримжааг зөрчих, нийтийн болон ахуйн амьдралын дэг журмыг аюулд учруулах, нийгмийн бүх гишүүн нийтээр хүлээн зөвшөөрч, дагаж мөрддөг ёс суртахууны үндсэн хэм хэмжээнд харшлах байдлаар илрэх ёстой. Энэ хэрэгт арбитрын бүрэлдэхүүн барьцааны бүртгэл хүчингүй болсон бодит үйл баримтад үндэслэн шийдвэр гаргасан болохоос Монгол Улсын эрүүгийн хэргийн шүүхийн шийдвэрийг арбитрын шийдвэр гаргах үндэслэл болгоогүй. Иймд маргаан бүхий арбитрын шийдвэр нь БНХАУ-д хүлээн зөвшөөрөөгүй Монгол Улсын эрүүгийн хэргийн шүүхийн шийдвэрийг БНХАУ-ын хэргийн оролцогч талд эрх зүйн үр дагавартай болгосон, БНХАУ-ын шүүх эрх мэдлийн бүрэн эрхт байдалд халдсан, нийгмийн нийтийн ашиг сонирхолд харшилсан нөхцөл байхгүй. Түүнчлэн уг маргаан нь эрх тэгш иргэний эрх зүйн субъектүүдийн хоорондын иргэний маргаан бөгөөд арбитрын шийдвэрийн үйлчлэл тэдгээрийн хоорондын эрх, ашиг сонирхолд хамаарна. Уг шийдвэр нь банкны тайлбарласан шиг БНХАУ-ын хөрөнгө оруулагчдын гадаадад санхүүгийн үйл

ажиллагаа явуулах дэг журмыг ноцтой алдагдуулсан, санхүүгийн тогтвортой байдал, аюулгүй байдалд халдсан, тодорхой этгээдээр хязгаарлагдахгүй нийт хөрөнгө оруулагчдын олон улсын санхүүгийн үйл ажиллагаанд оролцох аюулгүй байдал, итгэлийг эрсдэлд оруулсан зэрэг нийгмийн нийтийн ашиг сонирхолд харшлах нөхцөл байгааг одоо байгаа нотлох баримтаар нотлох боломжгүй. Хятадын Экспорт-Импортын банкны санхүүгийн хөрөнгө нь нийгмийн нийтийн ашиг сонирхолтой адил утгатай биш юм. Иймд банкны энэ үндэслэлийг тус шүүх хүлээн авахгүй.

Дээр дурдсаныг үндэслэн, “Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Арбитрын тухай хууль”-ийн 70 дугаар зүйл, “Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль”-ийн 291 дүгээр зүйлийг баримтлан ТОГТООХ нь:

Хятадын Экспорт-Импортын банкны хүсэлтийг бүхэлд нь хэрэгсэхгүй болгосугай.

Хүсэлт гаргасны хураамж болох 400 юанийг Хятадын Экспорт-Импортын банк хариуцна (төлсөн).

Даргалагч шүүгч Хао Вэньтин

Шүүгч Чэн На

Шүүгч Ли Шяорүй

(тамга)

Бээжин хотын Дөрөвдүгээр
дунд шатны ардын шүүх

2024 оны 6 дугаар сарын 27-ны өдөр

Шүүгчийн туслах Ма Ли

Нарийн бичгийн дарга Цүй Юйшинь